



**ТЭР ХААН МИНИЙ
ТӨЛӨӨ НАС БАРАХ**

БИ ХЭН БЭ?

БИ ХЭН БЭ?...

Бидний бүтээгч биднийг хэн бэ? гэдгийг мэддэг. Бурханы авралыг хүлээн авсанаар бид гэмээр удирдуулахгүй байхаар бүтээгдсэн гэдгээ Түүний үгнээс олж мэддэг.

Зарим нь Бурханы авралыг мэддэггүй. Зарим нь багахан мэддэг бөгөөд үүнийг хичээнгүйлэн хайх хэрэгтэй. Бусад хүмүүс Есүс Христ дотор маш агуу мөнхийн хувь заяатай хүн гэдгээ мэдэж, хүлээн зөвшөөрч байхад зарим нь Бурханы авралыг хүлээн авахын эсрэг тэмцдэг.

Бүтээгч үүнийг хийдэг гэдгийг миний мөнхийн сүнс хүлээн зөвшөөрөх нь зохицтой. Би Түүнийг мөнхөд хэрэгтүй мэт үзэж хүлээн авахгүй байж болно эсвэл Би итгэмжтэй дуулгавартай байдлаараа Түүнтэй хамт бүх ертөнцийн мөнхийн хаан ширээг хуваалцахыг ч хүлээн зөвшөөрч болно.

-Ватсон Гүүдмэн

БУРХАН БОЛ ХҮНИЙГ БҮТЭЭХ ЗОРИЛГОТОЙ ЭЗЭН

1

Тэр мөнхийн болзоот залуу байх болно

Сүйт залуу сүйт бүсгүйдээ баярладаг шиг чиний Бурхан чамд баярлана.

-Исаиа 62:56

Мөн тэнгэрийн хаанчлал нь шинэ хүргэнийг угтхаар дэнлүүгээ аваад гарсан арван охинтой төстэй юм. Гэтэл шөнө дөлөөр хашгирах дуун гарч „Хараач хүргэн байна. Түүнийг угтаж авцгаа,, гэлээ.

-Матай 25:1,6

Христ – шинэ хүргэн

Би Бурханлаг хардалтаар та нарыг хардаж байна. Учир нь би та нарыг ариун онгон охин мэт Христийн өмнө аваачихаар ганц нөхөртэй сүй тавиулсан.

-2Коринт 11:2

Бэр авагч нь шинэ хүргэн мөн. Харин зогсоод чагнагч найз нь шинэ хүргэний дуунд үлэмж баясдаг.

-Иохан 3:29a

Есүс тэдэнд .хэлсэн нь: Шинэ хүргэний бараа бологчид хүргэнтэйгээ хамт байхдаа гашуудаж болохгүй биз дээ? Гэвч хүргэн тэднээс аваачигдах өдрүүд ирнэ. Тэгэхэд тэд мацаг барина.

-Матай 9:15

Баярлан хөөрч, баясан цэнгэж, Түүнд алдрыг нь өргөцгөөс. Учир нь Хурганы хурим болж, Түүний сүйт бүсгүй өөрийгөө бэлтгэв.

-Илчлэлт 19:7

БУРХАН ЯАГААД ӨӨРИЙН ДҮР ТӨРХӨӨР ХҮНИЙГ БҮТЭЭСЭН БЭ?

Түүний сүйт бүсгүйн мөн чанраар бүтээв

Тэгээд Бурхан Өөрийнхөө дүр төрхөөр хүнийг бүтээж, Бурханы дүр төрхөөр эрэгтэй, эмэгтэй хүнийг бүтээв.
-Эхлэл 1:27

Түүний өмнө биднийг ариун бөгөөд гэм зэмгүй байлгахын тулд Бурхан ертөнцийн сууриас урьд биднийг Түүний дотор сонгосон. -Эфэс 1:4

Бурханы зохистой оролцоо

Ингэснээр та нар энэ дэлхийд тачаалаар байх ялзралаас ангижирснаар бурханлаг мөн чанарыг хуваалцагч болох юм... (2Петр 1:46). ...алдрыг хуваалцаг болохынхоо хувьд та нарын дундах ахлагчдыг ятгаж

байна. (1Петр 5:16).

...сайн мэдээгээр дамжуулан Христ Есүс дотор амлалтыг хамтран хуваалцагчид болгожээ (Эфэс 3:6б).

...Гэрэл дотор ариун хүмүүсийн өвийг хуваалцахад Тэр биднийг зохистой болгосон (Колоссай 1:12б). ...Яагаад гэвэл үр ашгийг нь хүртэгчид нь хайрлагдагсад ба итгэгчид шүү дээ... (1Тимот 6:2б). Учир нь хэрэв бил бат итгэлийнхээ эхлэлийг эцэс хүртэл бат сахивал Христийн хуваалцагчид болсон байна. (Еврей 3:14).

...тэнгэрлэг бэлгийг амссан, Ариун Сүнсний хуваалцагч болсон (Еврей 6:4б)> ...Тэгснээр бил Түүний ариун байдлыг хуваалцах юм (Еврей 12:10б).

...та нар бүгд надтай хамт нигүүслийг хуваалцдаг билээ (Филиппой 1:7б)

БИ БОЛ БУРХАНЫ ҮР УДАМ

3

Учир нь Бурхан Оөрийн дүрээр хүнийг бүтээжээ.

-Эхлэл 9:66

Бурхан, ертөнц хийгээд түүнд орших бүхнийг бүтээсэн ... амь, амьсгал хийгээд хамаг юмсыг бүгдэд өгдөг учраас ямар нэгэн юмаар дутагдсан мэт хүний гарыг Тэр өөртөө үйлчлүүлэхгүй. Бурхан газрын цээжээр амьдруулахаар нэгнээс хүмүүн төрөлхтний үндэстэн бүрийг бүтээв ... хүн Бурханыг эрж хайх ёстойн учир агаад Тэр бид бүхний хэнээс нь ч холгүй хэдий ч хүмүүс Түүнд хүрч. Түүнийг олоосой хэмээсэнд болой. Танай зарим яруу найрагчдын “Би бас Түүний үр удам” гэж хэлсэнчлэн, бид Түүний дотор амьдарч, хөдөлж, оршин тогтдог.

Бурханы үр удам атлаа бид Бурханлаг Мөн чанарыг хүний санаа, урлагийн тусгалыг тээгч алт, мөнгө эсвэл чулуун дүрстэй адилтган бодох ёсгүй.

-Үйлс 17:24a,25b,26a,27-29

Адам, Бурханы дүрээр бүтээгдсэн ба Бурханы алдар адил гэрэлтэн цацрах ёстой байв.

ЭЗЭНий цог жавхлан ЭЗЭНий өргөөг дүүргэсэн учраас тахилч нар үйлчлэлээ хийж чадахгүй байлаа.

-Хаадын дээд 8:11

Есүс ... тэдний өмнө хувирч өөрчлөгдөв. Түүний нүүр нар мэт гэрэлтэж, хувцас нь гэрэл мэт цагаан болсон байлаа.

-Матай 17:1a,2

АРИУНААС ГЭМ БА ХАРАНХҮЙ РҮҮ

**Бид Бурхантай адил бүтээгдсэн,
тэгвэл хэн ариун бэ?**

Яагаад гэвэл: “Би ариун учраас та нар ариун байгтун” гэж бичигдсэн юм.
-И Петр 1:16

Дуулгаваргүй учир салцаасан

Учир нь ганц хүний дуулгаваргүй байдлаас болж олон хүн нүгэлтэй болгогдононы адил түүнчлэн ганц Хүний дуулгавартай байдлаар олон хүн зөвт болгогдоно.

-Ром 5:19

-Бүгд нүгэл үйлдсэнээр Бурханы алдарт хүрдэггүй.
-Ром 3:23

Хуурамч ба муу санаатай болсон
Зүрх бол бүх зүйлээс илүү хуурамч бөгөөд эдгэршгүй өвчтэй юм. Үүнийг

хэн ойлгож чадах билээ?

-Иеремиа 17:9

ЭЗЭН дэлхий дээрх хүмүүсийн бузар гэм нь үлэмж их, бас тэдний сэтгэл санаа, хүсэл бодол бүхэн нь ямагт муухай болсныг хаав.

-Эхлэл 6:5

Бурханд муу санаатнууд гологдсон

“Би та нарт хэльс. Та нар хаанаас ирснийг Би мэдэхгүй. Бузрыг үйлдэгч та нар бүгд Надаас холд” гэнэ.

-Лук 13:276

Хүн харанхуйд хаягдсан

Тэрхүү ялалт ийм билээ. Гэрэл өртөнцөд ирэхэд хүмүүсийн үйлс бузар муу учир тэд харанхуйг гэрлээс илүү хайрласан юм.

-Иохан 3:19

ОДОО БУРХАНТАЙ ЯАЖ ХАРИЛЦАХ ВЭ?

5

Махан биеийн уналт нь ариун бус явдал юм

Бид бүгдээрээ бузар нэгэн мэт болсон бөгөөд бидний бүх зөв үйлс нь бохир хувцас мэт байдаг. Бид бүгдээрээ навч мэт хатаж, бидний нүгэл нь биднийг салхи мэт хийсгэнэ.

-Исаиа 64:6

Мөнхийн үхэл бол над дээр ирэх болсон

Тиймээс нүгэл нь ганц хүнээр ертөнцөд орсны адил үхэл нь нүглээр дамжуулан орж ирэв. Тэрчлэн бүгд нүгэл үйлдсэн тул бүх хүмүүст үхэл тархав.

-Ром 5:12

Би шийтгэгдсэн

Тиймээс нэг алдаа зөрчлөөс болж бүх хүмүүс ялд унасан... -Ром 5:18a

Гэмийн эрх мэдэл намайг олзолсон

Гэвч миний эрхтнүүдэд оөр хууль байдаг бөгөөд тэр нь миний оюун ухааны хуультай дайтаж, намайг өөрийн минь эрхтнүүдэд байдаг нүглийн хуулийн хоригдол болгодог юм байна гэдгийг би харж байна.

-Ром 7:23

Гэм нь Бурханаас салгасан

Харин та нарын гэм буруу нь та нарыг Бурханаас хагацуулдаг.

-Исаиа 59:2

Би Бурханд тайллагнадаг

Тиймээс бидний хүн бүр өөрийнхөө тайланг Бурханд өгөх болно.

-Ром 14:12

БИ ХЭН БЭ?

**Махан биеийн уналтанд би шавар,
өвс ногоо, уур манан адил болсон
Гэвч эдүгээ ЭЗЭН, Та бол бидний
Эцэг билээ. Бид шавар, Та бол бидний
ваарчин. Бид бүгдээрээ Таны мутрын
бүтээл.**

-Исаиа 64:8

**Учир нь: Бүх махан бие болбоос өвс
мэт бөгөөд бүхий л алдар нь өвс
ногооны цэцэг мэт. Өвс ганддаг, цэцэг
унадаг.**

-1Петр 1:24

**Амь чинь маргааш ямар байхыг та
нар мэдэхгүй. Учир нь та нар хэсэг зуур
үзэгдээд дараа нь алга болох уур манан
шүү дээ.**

-Иаков 4:14

**Би Христ дотор мартагдашгүй алдар
ба мөнхийн амьдралтай болж чадна**

**Амьд бөгөөд Надад итгэгч бүхэн
хэзээ ч үхэхгүй. Чи үүнд итгэж байна
уу? гэж асуув.**

-Иохан 11:28

**Бурханы Хүүд итгэдэг нэгэн нь
дотроо гэрчлэлтэй. Бурханд итгэдэггүй
хүн Түүнийг худалч болгож байна.
Учир нь Хүүгийнхээ тухай гэрчилсэн
Бурханы гэрчлэлд тэр итгэсэнгүй.
Гэрчлэл нь энд байна. Бурхан бидэнд
мөнх амийг өгсөн бөгөөд энэхүү амь
нь Түүний Хүүгий дотор байна. Хүүтэй
хүнд амь бий. Бурханы Хүү байхгүй
хүнд амь байхгүй.**

-1Иохан 5:10-12

АЛДРЫН ХААН ГЭЖ ХЭН БЭ?

7

Сүр жавхлангийн Хаан орж ирэхийн тулд дааман хаалгануудаа толгойгоо өргөж мөнхийн хаалгануудаа өргөгдөгтүн. Сүр жавхлангийн хаан гэж хэн бэ? Хүчтэй чадалтай ЭЗЭН. Тулалдаанд чадалтай ЭЗЭН юм. Сүр жавхлангийн Хаан орж ирэхийн тулд дааман хаалгануудаа толгойгоо өргөж, мөнхийн хаалгануудаа өргөгдөгтүн. Тэр Сүр жавхлангийн Хаан гэж хэн бэ? Түмэн цэргийн ЭЗЭН. Тэр бол Сүр жавхлангийн Хаан юм.

-Дуулал 24:7-10

Бидний Эзэн Есүс Христийг үзэгдэх хүртэл чи тушаалыг алдаа гаргалгүй гэм зэмгүйгээр сахь. Хаадын Хаан Эзэдийн Эзэн нь Зохистой цагт үүнийг харуулна. Тэр ганцаараа үхэшгүй

мөнхийг эзэмшдэг бөгөөд хүршгүй гэрлийн дотор оршдог. Ямар ч хүн Түүнийг хараагүй бөгөөд харж чадахгүй. Түүнд хүндэтгэл ба мөнх хүч нь байх болтугай. Амен.

-1Тимот 6:14,156,16

Хаан нь бүх газрын дээрх хаан болох болно

Тэр өдөр амийн ус Иерусалимаас урсан гарч, хагас нь дорнын тэнгис уруу нөгөө хагас нь өрнийн тэнгис уруу чиглэнэ. Энэ нь өвөл зунгүй урсах болно. ЭЗЭН бүх дэлхийн хаан болж, тэр өдөр ЭЗЭН нь цорын ганцаар байж, Түүний нэр нь цорын ганц байх болно.

-Зехария 14:8,9

ЕСҮС ХРИСТ ӨӨРИЙН ХААНЧЛАЛЫГ ТУНХАГЛАСАН

Есүс: Миний хаанчлал бол энэ ертөнцийнх биш ээ. Хэрэв Миний хаанчлал энэ ертөнцийнх байсан бол Намайг Иудейчүүдийн гарт өгөхгүйн тулд Миний зарц нар тэмцэх байсан. Харин одоо Миний хаанчлал эндхийнх биш гэлээ. Пилат Түүнд: Тэгэхлээр Та хаан байх нь ээ? гэхэд Есүс: Намайг Хаан гэж та хэлж байна. Учир нь Би үнэний тухай гэрчлэхээр төрсөн бөгөөд үүний тулд л ертөнцөд ирсэн. Үнэний хүн бүр Миний дууг сонсоно гэж айлдлаа.

-Иохан 18:36, 37

Гэвч Есүс дуугүй байж, ямарч хариулт өгсөнгүй. Тэргүүн тахилч дахиж Түүнээс асуун: Та Ерөөлт Нэгэний Хүү, Христ мөн юм уу? гэлээ.

Есүс: Би мөн. Та нар Хүний Хүү Хүчит Нэгэний баруун гарг сууж тэнгэрийн үүлсийн дунд ирэхийг харна гэв.

-Марк 14:61,62

Хүний Хүү алдраа дуурсан бүх тэнгэр элч нарынхаа хамт ирж Өөрийн сүр жавхлант сэнтийндээ залрах болно. Тэгээд Хаан Өөрийн баруунтайд байгсадад хандан хэлэх нь: Миний Эцэгээр срөөгдөгсөдөө, та нар нааш ир. Ертөнцийн сууриас та нарт бэлтгэсэн хаанчлалыг өвлөн авсугай.

-Матай 25:31,34

ЕСҮС ХРИСТИЙН ХААНТ УЛСЫН МӨН ЧАНАР

9

Харин Хүүгийн тухай: Бурхан минь Таны хаан ширээ үеийн үед, Таны хаанчлалын очирт таяг бол зөвт очирт таяг мөн.

-Еврей 1:8

Одоо Небухаднезар би тэнгэрийн Хааныг магтан, өргөмжлөн хүндэлж байна. Учир нь Түүний бүх үйлс үнэн бөгөөд Түүний замууд зөв билээ. Тэрээр бардам явж буй хүнийг даруу болгож чадна.

-Даниел 4:37

Үнэнээр Би та нарт хэлнэ: Та нар өөрчлөгдөж хүүхдүүдтэй адил болохгүй бол тэнгэрийн хаанчлалд орохгүй. Иймээс хэн өөрийгөө энэ хүүхэд адил даруу болгоно, тэр нь тэнгэрийн

хаанчлалд хамгийн агуу нь болно.

-Матай 18:3,4

...бидний Эзэний болон Түүний Христийн хаанчлал болсон. Тэр үеийн үед хаанчлана гэх чанга дуу гарлаа.

-Илчлэл 11:156

Та нарын зүрхний мэлмийг гийгүүлэгдэг. Тэгвэл та нар Түүний дуудлагын найдвар юу болохыг, ариун хүмүүс дотор Түүний өвийн алдрын баялаг юу болохыг, мөн итгэдэг бидэнд хандсан Түүний хүч чадлын хэмжээлшгүй сүр жавхлан юу болохыг мэдэх болно. Эдгээр нь Түүний хүчит чадлын үйлдлийн дагуу бөгөөд...

-Эфэс 1:18,19

ХААНЫ АЛДРЫН ШИНЖ ЧАНАР

Таны Надад өгсөн бүх хүнд Хүү чин мөнх амийг өгөхийн тулд бүх махан биеийг захирах эрхийг Та Надад өгсөн билээ.

-Иохан 17:2

Тэрээр Оөрийнх нь эрхэнд тэнгэр элч нар, эрх мэдлүүд болон хүчинүүд захирагдсаны дараа тэнгэрт очоод Бурханы баруун гарт байгаа билээ.

-1Петр 3:22

Тэрээр Христ дотор хүч чадлаа үзүүлж, Түүнийг үхэгсдээс амилуулаад тэнгэрлэг газарт Оөрийн баруун гарт залж, бүх засаг захиргаа, эрх мэдэл, хүч, ноёрхол төдийгүй зөвхөн энэ үед ч биш мөн ирээдүйд нэрлэгдэх аливаа нэрээс ч эрхэм болгожээ. Бурхан бүх юмсыг Түүнд захируулахаар хөл дор нь тавьж

Түүнийг чуулганы төлөө бүх юмсын дээрх Тэргүүн болгожээ. Чуулган нь Түүний бие буюу бүхний дотор бүтгдийг Дүүргэгчийн дүүрэн байдал нь мөн.

-Эфес 1:20-23

Харин Оөрийнхөө хувьд Есүс Оөрийгөө тэдэнд даатгасангүй учир нь тэр бүх хүнийг мэдэж байв. Хүний дотор юу байдгийг мэдэж байсан тул хүний тухай хэн нэгэний гэрчлэл Түүнд хэрэггүй байв.

-Иохан 2:24,25

Би тэдний дотор, Та Миний дотор байдаг. Ингэснээр тэд төгс нэгдэн, Таны Намайг илгээснийг болон Намайг хайрласаны адил тэднийг хайрласаныг ертөнц мэдэх болно.

-Иохан 17:23

ХЭМЖЭЭЛШГҮЙ БАЯЛАГ, ХҮЧ БА МЭРГЭН УХААН

11

“Нядлуулсан Хурга хүч, баялаг, мэргэн ухаан, сүр хүч, хүндэтгэл, алдар ба магтаалыг авбал зохистой.”

-Илчлэлт 5:12

Есүс ойртон ирээд, тэдэнд: Тэнгэр газар дээрх бүх эрх мэдлийг Надад өгсөн.

-Матай 28:18

Бидний хувьд ганц Бурхан, Эцэг байна. Бүх юм Түүнээс гарсан бөгөөд бид Түүний төлөө юм. Мөн ганц Эзэн Есүс Христ байна. Бүх юм Түүгээр байгаа бөгөөд бид ч Түүгээр байгаа юм.

-Илчлэлт 8:6

Харин дуудагдсан хүмүүст нь, иудейчүүд, грекчүүдийн хэн хэнд нь

Христ бол Бурханы хүч хийгээд Бурханы мэргэн ухаан мөн.

-Илчлэлт 1:24

Байгаа, байсан, Төгс хүчтэй Эзэн Бурхан минь ээ, Танд бид талархал өргөе. Яагаад гэвэл Та Оөрийн агуу их хүчээ авч, хаанчилж эхэллээ.

-Илчлэлт 11:17

Ингэсэнээр тэдний зүрх хайрын дотор холбогдон, Бурханы нууцын жинхэнэ мэдлэг болох Христ уруу аваачдаг бүрэн итгэлт ойлголтоос ирдэг бүх баялагт хүрэн, урамшдаг. Христ дотор мэргэн ухаан болон мэдлэгийн бүх эрдэнэс нуугдсан байдаг.

-Колоссай 2:2,3

ХААНЫ АЛДРЫН ИРЭЭДҮЙ

Тэрээр далайгаас далай хүртэл, мөрнөөс газрын хязгаар хүртэл захирах болтугай. Бүх хаад түүний өмнө сөгдөж, бүх үндэснүүд түүнд зарагдах болтугай.

-Дуулал 72:8,11

Газар дэлхийн хаад бат зогсож, удирдагчид хоорондоо зөвлөлдөж, Эзэн ба Түүний тослогдсон Нэгэнийг эсэргүүцэн бид тэдний гинжийг тасалж хүлгийг нь өөрсдөөсөө зайлцуулцгаая гэж тэд хэлэв. Миний ариун уул Сионд Би Өөрийн хааныг өргөмжилсөн гэнэ. Би Эзэний зарлигийг тунхаглана. Тэр надад хэлэхдээ: Чи бол Миний Хүү. Өнөөдөр Би Чамайг төрүүлсэн, Надаас гуй! Би үндэстнүүдийг Чиний өв болгон дэлхийн хязгааруудыг ч Чиний

эзэмшил болгон өгнө.

-Дуулал 2:2-4,6-8

Үндэстнүүдийн Хаан, Танаас хэн айхгүй байх билээ? Үнэхээр энэ нь Танд зохистой. Учир нь үндэстнүүдийн хамаг мэргэн хүмүүсийн дунд болон тэдний хамаг хаанчлалуудад Тантай адил хэн ч үгүй. Харин ЭЗЭН бол жинхэнэ Бурхан. Тэр бол амьд Бурхан бөгөөд мөнхийн Хаан.

-Иеремиа 10:7,10а

Би бол ЭЗЭН. Энэ бол Миний нэр.
Би Өөрийн алдрыг бусдад, Өөрийн
магтаалыг сийлмэл хөргүүдэд өгөхгүй.

-Исаиа 42:8

Учир нь ЭЗЭН бол агуу Бурхан ба
бүх бурхадын дээр агуу Хаан юм.

-Дуулал 95:3

Тэгээд Хүний Хүүгийн тэмдэг
тэнгэрт илэрхийлэгдэхэд газрын бүх
овог гашуудан уйлж, Хүний Хүүг
тэнгэрийн үүлэн дээр сүр хүч болоод
агуу цог жавхлантайгаар ирэхийг
харна.

-Матай 24:30

Бидний Эзэн ба Бурхан минь, Та
алдар хүндэтгэл хүчийг авах нь
зохистой. Учир нь Та бүх юмсыг

бүтээсэн билээ. Таны хүслийн улмаас
тэдгээр нь оршсон бөгөөд бүтээгдсэн
гэх ажээ.

-Илчлэлт 4:11

Үеүдийн Хаан, үхэшгүй, үл үзэгдэх
цорын ганц Бурханд хүндлэл ба алдар
нь үеийн үед байх болтугай. Амен.

-1 Тимот 1:17

Бид нэг байдгийн адил тэднийг нэг
байлгахын тулд Таны Надад өгсөн сүр
жавхланг Би тэдэнд өгсөн билээ.

-Иохан 17:22

Учир нь энэхүү өнөө үеийн
зовлонгууд нь бидэнд илчлэгдэх тэрхүү
алдартай зүйрлүүлшгүй гэж би боддог.

-Ром8:18

БҮТЭЭГЧ ХААНЫ ЗАРЛИГ

Давидын сэntий, түүний хаанчлалд шударга ёс, үnэн зөвийг үeийн үed тогтооход, Түүний засаглал болон энх амгалан нь одоогоос үүрд мөнхөд байх болно.

-Исаиа 9:7а

Бүтээгчтэйгээ маргалдагчид хөөрхий еэ! Шавар сав нь газрын савнуудтай хамт байг. Эцэгтээ : Та юу төрүүлэв? Ээждээ: Та юу гаргачихсан юм бэ? гэж ярьдаг хүн хөөрхий еэ! Израилийн ариун Нэгэн, Бүтээгч нь болох ЭЗЭН үүнийг айлдаж байна. “Миний хөвгүүдийн талаар ирээдүйд болох юмыг та нар Надаас асуугтун. Миний мутрын ажлын талаар та нар Надад тушаах уу? Дэлхийг бүтээж, дээр нь хүнийг буй болгосон нь Би мөн. Би Өөрийн мутраараа тэнгэрийг дэлгээд, тэднийг бүх эздийг нь

томилов. Би түүнийг үnэн зөвийн дотор босгон, бүх замыг нь тэгшилнэ. Тэр ямар ч хөлс, шагналгүйгээр Миний хотыг барьж, Миний хоригдлуудыг чөлөөтэй явуулна” гэж түмэн цэргийн ЭЗЭН айлдав.

-Исаиа 45:9a,10-13

Түүнд эрх мэдэл, сүр жавхлан ба хаачлал өгөгдөж, бүх ард түмэн, үндэстэн, бүх хэлтэн Түүнд үйлчлэв. Түүний ноёрхол үүрдийн ноёрхол бөгөөд өнгөрөн одохгүй. Түүний хаанчлал нь устахгүй хаанчлал юм.

-Даниел 7:14

Түүний зарлигт сөхрөх болно!

Бүх хаад Түүний өмнө сөгдөж, бүх үндэстнүүд Түүнд зарагдах болтугай.

-Дуулал 72:11

ХААНЫ АЛДАР МИНИЙ ТӨЛӨӨ ҮХСЭН!

15

**Үхэл ба амилалтын тухай урьдаас
мэдэж байсан**

Харагтун, бид Иерусалимыг зорин явж байна. Хүний Хүү ахлагч тахилч нар, хуулийн багш нарын гарташаагдах бөгөөд тэд Түүнийг алахаар яллаж, харь үндэстэнд тушааж, тэд нараар доромжуулж, ташуурдуулж, цовдуулна. Гурав дахь өдрөө Тэр амиллах болно гэлээ.

-Матай 20:18,19

**Гэм бол Бурханы хараанд
бузар зүйл юм**

Учир нь Христ ч биднийг Бурханд аваачихын тулд зөвт нь зөвт бус хүмүүсийн оронд нэг удаа нүглийн төлөө үхсэн. Ингэхдээ махан бие дотор үхэж, сүнс дотор амилуулагдав.

1Петр 3:18

Бидний Эцэг Бурхан ба Эзэн Есүс Христээс нигүүлсэл болон амар тайвань та нарт байх болтугай. Бидний Бурхан ба Эцэгийн хүслээр одоогийн бузар булагай энэ үеээс биднийг гэтэлгэхийн тулд бидний нүглийн төлөө Есүс Христ Өөрийгөө өгсөн юм.

-Галат 1:3,4

Бидний төлөө Тэр Өөрийн амия өгсөн тул, үүгээр бид хайрыг мэднэ. Бид ч ах дүүсийнхээ төлөө амия өгөх ёстой.

-1Иохан 3:16

Загалмайн үг нь мөхөгсдийн хувь мунхаг явдал боловч аврагдаж байгаа бидний хувьд Бурханы хүч мөн.

-1Коринт 1:18

ҮНЭТЭЙ ЦУС-ҮНЭТЭЙ АВРАГЧ

Харин урьд нь алс хол байсан та нар эдүүгээ Христ Есүс дотор Христийн цусаар ойр болов. -Ефес 2:13

...Есүсийн цусаар, өөрийн махан бие болох хөшгөөр дамжуулан Түүний нээсэн шинэ, амьд замаар ариун газарт нэвтрэн орох итгэл байгаа.

-Еврей 10:19-20

...бидний Эзэн Есүсийг мөнх гэрээний цусаар дамжуулан үхэгсдээс амилтуулсан амар амгалангийн Бурхан.

-Еврей 13:20б

Түүний загалмайн цусаар энх тайвныг тогтоон, Түүгээр дамжуулан газар дээрх эсвэл тэнгэр дэх юмыг, бүх юмыг Түүгээр Оөртэйгээ звлэрүүлэх явдал байв.

-Колоссай 1:20

Биднийг хайлрадаг бөгөөд Өөрийнхөө цусаар биднийг нүглээс минь чөлөөлж. -Илчлэл 1:5б

"Харагтун, Би Сионд сонгогдсон, Булангийн үнэт чулууг тавина. Түүнд итгэгч хүн ичгүүрт орохгүй" хэмээн агуулагдсан байдаг. Тиймээс энэхүү хүндэтгэл нь итгэгч та нарын төлөө ажээ. Харин үл итгэгчдэд "Барилгачдын голсон чулуу нь булангийн чулуу болов"

-1 Петр 2:6-7

Христ Есүст итгэх итгэлээр дамжуулан авралд хүргэх мэргэн ухааныг чамд өгөх чадалтай Ариун Бичээсүүдийг чи бага нааснаасаа мэдэх болсон.

-2 Тимот 3:15

Шинэ хүргэн Өөрийн сүйт бүсгүйг хайж байна

Хүний Хүү алдагдсаныг хайж, аврахаар ирсэн билээ гэв. -Лук 19:10

ХРИСТ НАМАЙГ АВРАХЫН ТУЛД ХОЁР ДАХЬ ҮХЭЛ БА ТАМЫГ ЯЛСАН ЮМ

17

Би мөнхөд үхэх гавьяатай байсан
Нүглийг үйлдэгч сэтгэл нь үхэх
болно.

-Езекиел 18:46

Тиймээс нүгэл нь ганц хүнээр
ертөнцөд орсны адил үхэл нь нүглээр
дамжуулан орж ирэв. Тэрчлэн бүгд
нүгэл үйлдсэн тул бүх хүмүүст үхэл
тархав.

Ром 5:12

Учир нь нүглийн хөлс бол үхэл.
-Ром 6:23а

Үхэл намайг ялсан байсан
Тиймээс бидний Эзэний гэрчлэлээс
бүү ич. Түүний хоригдол надаас ч бүү
ич. Харин Бурханы хүчээр сайн
мэдээний төлөө зовлон дотор надтай

холбогд. Бурхан биднийг ажил үйлсээр
минь биш, харин Өөрийнхөө зорилго
болон бүх л өнө мөнхөөс Христ Есүс
дотор бидэнд соёрхсон нигүүлслийн
дагуу аварсан. Тэр биднийг ариун
дуудлагаар дуудсан байна. Харин
эдүгээ энэ нь бидний Аврагч Христ
Есүсийн үзэгдсэнээр илчлэгджээ. Тэр
үхлийг устган, амь үхэшгүй байдлыг
сайн мэдээгээр дамжуулан гэрэлд
авчирсан.

-2Тимот 1:8-10

Амьд Нэгэн мөн. Би үхсэн байсан.
Харагтун, Би үсийн үед амьд байна.
Надад үхэл ба Үхэгсдийн орны түлхүүр
бий.

-Илчлэлт 1:18

ХЭН ХҮСНЭ ТЭР НЬ ХААНЫ АВРАЛЫН ЭРХ ЧӨЛӨӨГ АВАХ БОЛНО

Судрын дагуу Христ бидний нүглийн төлөө үхсэн бөгөөд.

-1 Коринт 15:36

Бурханы чуулганыг хариулулахаар Ариун Сүнс та нарыг харгалзагч болгосон бөгөөд та нар өөртөө болон бүх сүрэгт анхаарал тавь.

-Үйлс 20:286

Би бол сайн хоньчин мөн. Сайн хоньчин хоньдынхоо төлөө амиа өгдөг.

-Иохан 10:11

Тэр бүгдийн төлөө үхсэн учраас амьд байгасд цаашид өөрсдийн төлөө бус, харин өөрсдийнх нь төлөө үхээд, амилуулагдсан Түүний төлөө амьдрах ёстой.

-2Коринт 5:15

“Түүнд итгэсэн хэн боловч Түүний нэрээр нүглийн учалалыг хүлээн авдаг гэж бүх эш үзүүлэгчид гэрчилдэг гэв”

-Үйлс 10:43

Өөр хэний ч дотор аврал үгүй. Учир нь бид аврагдаж болох өөр нэр тэнгэрийн доор хүмүүст өгөгдсөнгүй гэв.

-Үйлс 4:12

Эзэн удаашралыг тооцдог зарим хүмүүсийн боддог шиг Өөрийнхөө амлалтад хойрго биш билээ. Харин ч Тэр хэнийг ч мөхүүлэхийг хүсэлгүй, бүгдийг гэмшилд ирээсэй хэмээн үхсэн та нарт тэвчээртэй ханддаг.

-2Петр 3:9

Та нар Намайг хайх бөгөөд бүхий л зүрхээрээ Намайг хайвал олно.

-Иеремиа 29:13

БУРХАН БА НҮГЭЛ ХООРОНДЫН ӨШӨӨ ХОРСОЛ

19

Бурхан, Таны сэентий мөнхийн мөнхөд болой. Шударга ёсны очирт таяг бол Таны хаанчлалынх юм. Та зөв шударгыг хайлралж, хорон мууг үзэн ядсан.

-Дуулал 45:6,7а

Эсвэл та нар зөвт бус хүмүүс Бурханы хаанчлалыг өвлөхгүй гэдгийг мэддэгтүй гэж үү?

-1 Коринт 6:9а

Учир нь махан биеийн дагуу байгчид нь махан биеийн юмсыг боддог. Харин Сүнсний дагуу байгчид нь Сүнсний юмсыг боддог. Махан биеийн бодол санаа бол үхэл, Сүнсний бодол санаа бол амь ба амар тайван болой. Яагаад гэвэл махан биеийн бодол санаа бол Бурханы эсрэг дайсагнал юм. Учир нь энэ нь Бурханы

хуульд захирагдаггүй бөгөөд тэгж чадах ч үгүй. Махан бие дотор байгсад Бурханд таашаагдаж чадахгүй. Хэрэв Бурханы Сүнс үнэхээр та нарын дотор оршиж байвал, та нар махан бие дотор бус, харин Сүнс дотор байна. Хэрэв хэн нэгэнд Христийн Сүнс байхгүй бол тэр Түүнийх биш.

-Ром 8:5-9

Завхай эмс ээ, ертөнцтэй найзлах нь Бурханы эсрэг дайсагнал гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? Тэгэхлээр ертөнцийн найз байхыг хүссэн хэн боловч өөрийгөө Үурханы дайсан болгож байгаа юм.

-Иаков 4:4

ЯАЖ ХААНААР ХҮЛЭЭН АВСАН ВЭ?

Гэм нүглээ нуун далдлагч хэзээ ч амжилтанд хүрэхгүй. Харин гэм нүглээ хүлээн зөвшөөрч, тэдгээрийг мартдаг хүн хайр энэрлийг хүртэнэ.

-Сургаалт үгс 28:13

Бурхан биднийг хайлрадаг хайрыг нь бид мэдэж, итгэдэг. Бурхан бол хайр мөн. Хайр дотор байгч нэгэн нь Бурханы дотор байж, Бурхан түүний дотор байна.

-Иохан 4:16

Харин Өөрийг нь хүлээн авсан болгонд, Өөрийнх нь нэрд итгэдэг хүмүүст Бурханы хүүхэд эрхийг тэр өгөв.

-Иохан 1:12

Үнэнээр үнэнээр, Би та нарт хэлье. Миний илгээдэг хэнийг боловч хүлээн авч буй хүн Намайг хүлээн авдаг. Намайг хүлээн авдаг хүн Намайг Илгээгчийг хүлээн авдаг гэж айлдлаа.

-Иохан 13:20

Тэд замаараа явсаар устай газар хүрч иржээ. Тайган хүн: Хараач, ус байна. Баптист хүртэхэд болохгүй нь ю билээ гэв. Филип: Хэрэв чи бүх зүрхээрээ итгэвэл, болно гэсэнд: Есүс Христ бол Бурханы Хүү мөн гэдэгт би итгэж байна хэмээн хариулав.

-Үйлс 8:36,37

Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Миний үгийг сонсоод Намайг илгээгч Түүнд итгэгч нь мөнх амьтай болох бөгөөд яллагдахгүй. Харин үхлээс өнгөрч амь уруу шилжив.

-Иохан 5:24

Та нарын итгэл хүмүүсийн мэргэн ухаан дотор бус, харин Бурханы хүч дотор байхын тулд юм. -1 Коринт 2:5

Есүс Өөрт нь итгэсэн иудейчүүдэд: Хэрэв та нар Миний үгэн дотор байвал үнэхээр Миний дагалдагчид байна.

-Иохан 8:31

АВРАЛ БОЛ АМЬД ХАРИЛЦАА БА ХРИСТ ДЭХ НӨХӨРЛӨЛ ЮМ

21

Мэдлэгийг давдаг Христийн хайрыг мэдсэнээр та нар Бурханы бүх дүүрэнд хүртэл бялхсан байх болтугай.

-Эфес 3:19

Бурхан бол итгэмжит. Та нар бол Түүгээр дамжуулан Түүний Хүү нь болох бидний Эзэн Есүс Христтэй нөхөрлөхөөр дуудагдсан юм.

-1Коринт 1:9

Хэрэв Христ та нарын дотор байгаа бол, нүглээс болж бие нь үхмэл хэдий ч, зөвт байдлын улмаас сүнс нь амьд байна.

Ром 8:10

Та нар Миний хонин сүрэг биш учир итгэдэггүй. Миний хонин сүрэг дууг минь сонсдог. Би тэднийг мэддэг бөгөөд тэд Намайг дагадаг юм. Би

тэдэнд мөнх амийг өгнө. Тэд хэзээ ч мөхөхгүй бөгөөд тэднийг хэн ч Миний гараас булаахгүй.

-Иохан 10:26-28

Энэхүү шалтгааны улмаас би мөн зовдог. Гэхдээ би ичдэггүй . Учир нь би хэнд итгэсэнээ мэддэг. Тэр надад хариуцуулсан зүйлээ тэрхүү өдрийг хүртэл хамгаалах хүчтэй гэдэгт би итгэлтэй байна.

2Тимот 1:12

Тиймээс Бурханы хүслийн дагуу зовогсод зөвийг үйлдэхдээ итгэмжит Бүтээгчид сэтгэлээ даатгаг.

-1Петр 4:19

ДАХИН ТӨРСӨН, ЭЗЭНД ҮЙЛЧЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Есүс бол Бурханы Хүү мөн гэж итгэдэг хүнээс өөр хэн өртөнцийг ялагч байх вэ?

-Иоган 5:5

Тэд цусаар биш махан биеийн хүслээр ч биш, хүний хүслээр ч биш харин Бурханы төрөгсөд билээ.

-Иохан 1:13

Тэгээд та нар үнэнийг ойлгож, үнэн та нарыг чөлөөлнө гэсэнд

-Иохан 8:32

Эзэн бол Сүнс мөн. Эзэний сүнс хаана байна, тэнд эрх чөлөө байдаг.

-2Коринт 3:17

Иймээс хэрэв Хүү та нарыг чөлөөлбөл та нар үнэхээр эрх чөлөөтэй болно.

-Иохан 8:36

Нүглээс чөлөөлөгдөн зөвт байдлын боолууд болсон. Харин одоо нүглээс чөлөөлөгдсөн бөгөөд Бурханд боолчлогдсон та нарт ариусгалд хүрах үр жимс авдаг. Төгсгөл нь мөнх амь болой.

-Ром 6:18 ба 22

Христ биднийг эрх чөлөөтэй болгохын тулд чөлөөлсөн юм. Иймд бат зогс, дахиж боолчлолын буулганд бүү орогтуун.

-Галат 5:1

Учир нь чи үзсэн, сонссон зүйлээ бүх хүмүүсийн өмнө гэрчлэх Түүний гэрч болно.

-Үйлс 22:15

Эсвэл та нар зөвт бус хүмүүс Бурханы хаанчлалыг өвлөхгүй гэдгийг мэддэггүй гэж үү? Бүү мэхлэгдэгтүн. Садар самуун явдалтнууд ч, шүтээн шүтэгчид ч, завхайрагчид ч, янхан эр ч, ижил хүйстэнтэйгээ нөхцөгчид ч, хулгайч нар ч, шуналтангууд ч, архичид ч, хараалчид ч, дээрэмчид ч, Бурханы хаанчлалыг өвлөхгүй. Та нарын зарим нь тийм байсан. Гэвч Эзэн Есүс Христийн нэрээр болон бидний Бурханы Сүнс дотор та нар угаагдсан, та нар ариусгагдсан, та нар зөвтгөгдсөн юм.

-1 Коринт 6:9-11

Мөн итгэмжит гэрч ба үхэгсдээс анх төрсөн бөгөөд газрын хаадын захирагч Есүс Христээс нигүүлсэл ба амар тайван нь та нарт байх болтугай. Биднийг хайралдаг бөгөөд Өөрийнхөө цусаар биднийг нүглээс минь чөлөөлж,

биднийг хаанчлал болоод Бурхан ба Өөрийн Эцэгийн толөөх тахилч нар болгосон. Түүнд үеэс үед алдар хийгээд ноёрхол нь байх болтугай. Амен.

-Илчлэл 1:5-6

Эсвэл ертөнцийг ариун хүмүүс шүүнэ гэдгийг та нар мэддэггүй юм уу? Хэрэв та нар ертөнцийг шүүх юм бол багахан хэргийг шүүх чадваргүй юу?

-1 Коринт 6:2

Чи Эзэний мутар дахь үзэсгэлэнт титэм, өөрийн Бурханы мутар дахь хааны малгай болно.

-Исаиа 62:3

Байр сууринд өргөсөн

Энэ нь Эцэг Та Миний дотор, Би Таны дотор байгаатай адил, тэд бүгдээрээ нэг байхын тулд бөгөөд мөн тэд Бидний дотор байж, Таны Намайг илгээсэн гэдэгт ертөнцийг итгүүлэхийн тулд билээ.

-Иохан 17:21

БУРХАНТАЙ НӨХӨРЛӨХИЙН ТУЛД БҮТЭЭГДСЭН

Эзэн Өөрийг нь дуудагч бүхэнд,
Өөрийг нь үнэхээр дуудагч бүхэнд ойр
байдаг.

-Дуулал 145:18

Бурханы сүм ба шүтээнүүдийн
хооронд ямар зөвшилцөл байх билээ?
Учир нь бид амьд Бурханы сүм мөн.
Бурхан айлдахдаа Би тэдний дотор
оршино, Би тэдний дунд алхана. Би
тэдний Бурхан болно. Тэд Миний ард
түмэн болно.

-2Коринт 6:16

Харин та нар Христийн
зовлонгуудыг хуваалцагтаа баярла.
Ингэснээр мөн Христийн алдар
илчлэгдэхэд та нар баяр хөөртэйгөөр
баярлах юм.

-1Петр 4:13

Бид үзсэн, сонссоноо та нарт мөн
тунхаглаж байна. Ингэснээр та нар бас
бидэнтэй нөхөрлөх юм. Үнэхээр
бидний нөхөрлөл нь Эцэг ба Түүний

Хүү Есүс Христтэй нөхөрлөх нөхөрлөл
билээ.

-1Иохан 1:3

Чамайг ус гатлахад Би чамтай хамт
байна. Голоор туулахдаа чи живэхгүй.
Гал дундуур явсан чи түлэгдэхгүй,
дөл нь чамайг шатаахгүй.

-Исаиа 43:2

Би тэдний дотор, Та Миний дотор
байдаг. Ингэснээр тэд төгс нэгдэнэ, Та
Намайг илгээснийг болон Намайг
хайрласны адил тэднийг хайрласныг
ертөнц мэдэх болно.

-Иохан 17:23

Аав аа, Таны Надад өгсөн хүмүүс
бас Миний байх газарт Надтай хамт
байж, Миний сүр жавхланг үзээсэй
гэж Би хүсэж байна. Тэр сүр жавхланг
Та Надад өгсөн билээ. Учир нь
ертонцийн сууриас өмнө Та Намайг
хайрласан.

-Иохан 17:24

ХРИСТ БА ҮНЭН ИТГЭГЧДИЙН ХООРОНДИЙН ХАРИЛЦАА

25

Би Өөрийн Эцэг дотор, та нар
Миний дотор, Би та нарын дотор
байхыг та нар тэр өдөр мэдэх болно.

-Иохан 14:20

**Түүний сүүлчийн тушаал, бидний
анхны ажил үйлс**

Сүns болон сүйт бүсгүй: Ирээрэй
гэнэ. Сонсогч нь: Ирээрэй гэж хэлэг.
Цангасан нэгэн нь ирэг. Хүссэн нэгэн
нь амийн усыг үнэгүй аваг.

-Илчлэлт 22:17

Иймээс явж, бүх үндэстнийг
дагалдагч болгогтун. Эцэг, Хүү, Ариун
Сүnsний нэрээр тэдэнд баптисм
хүртээж, Миний та нарт тушаасан
бүгдийг сахин биелүүлэхийг тэдэнд
заа. Харагтун, үеийн төгсгөл хүртэл Би
та нартай үргэлж хамт байх болно гэж
айлдав.

-Матай 28:19,20

**Итгэгчдийн зөвт байдал бол Христ
доторх зөвт байдал юм**

Бурхан харь үндэстнүүдийн дунд
энэхүү нууцын алдрын баялаг гэж юу
боловхыг тэдэнд мэдүүлэхийг хүссэн
юм. Энэ нь та нарын дотор байгаа
алдрын найдвар болох Христ мөн.

-Колоссай 1:27

**Бид хүн бүрийг Христ дотор төгс
болгохын тулд бүх мэргэн ухаан дотор
хүн бүрт сануулж, хүн бүрт заан
Түүнийг тунхаглаж байна.**

-Колоссай 1:28

**Учир нь итгэдэг хүн бүрт зөвт
байдлын төлөө Христ бол хуулийн
төгсгөл мөн.**

-Ром 10:4

ИЙМ ИХ ӨРШӨӨЛ, ИЙМ ИХ ХАЙР БА ИЙМ ИХ НИГҮҮЛСЭЛ

Бидний Эзэн Есүс Христийн Бурхан болон Эцэг магтагдах болтугай. Учир нь Бурхан Өөрийн агуу их өршөөлөөрөө Есүс Христийн үхэгсдээс амилсан амилалтаар дамжуулан биднийг амьд найдвартай уруу.

-1Петр 1:3

Тиймд бид хэрэгцээтэй цагт туслах нигүүлслийг олон, өршөөлийг хүлээн авахын тулд нигүүлслийн хаан ширээнд итгэлтэйгээр ойртон очицгооё.

-Еврей 4:16

Харин Бурхан өршөөлөөр баян ажээ. Тэр биднийг хайрласан Өөрийн агуу хайраар биднийг гэм нүгэл дотор үхсэн байхад Христтэй хамт амьд болгосон юм. Та нар нигүүлслээр

аврагдсан билээ. Биднийг Түүнтэй хамт амилтуулж, тэнгэрлэг газарт Христ Есүс дотор Түүнтэй хамт суулгасан нь Христ Есүс дотор бидэнд хандсан энэрлээр Өөрийн нигүүлслийн хэмжээлшгүй баялгийг ирэх үеүдэд үзүүлэхийн тулд юм.

-Эфэс 2:4-7

Христ дотор та нарыг Өөрийн мөнх алдар уруу дуудсан, бүх нигүүлслийн Бурхан Өөрөө та нарыг түр зуур зовсоны дараа та нарыг төгс болгож, бататгаж, бэхжүүлэн байгуулах болно.

-1Петр 5:10

Харин Христ Есүс доторх золилтоор дамжуулан Түүний нигүүлслээр үнэгүй зөвтгөгдсөн билээ.

-Ром 3:24

Харин цаг нь болоход Бурхан эмэгтэй хүнээс Хуулийн дор төрөх Оөрийн Хүүгээ илгээсэн юм. Энэ нь Хуулийн дор байгсдыг золихын тулд юм. Ингэснээр бид хөвгүүд нь адил үрчлэлийг авах юм.

-Галат 4:4-5

Бид Бурханы хүүхдүүд гэж дуудуулхаар ямар хайрыг Эцэг билэнд соёрхсоныг хараач! Бид бол тийм юм. Иймээс ертөнц Түүнийг мэдээгүй тул биднийг мэддэггүй.

-Иохан 3:1а

Бурханы өв залгамжлагч

Ялагч нь эдгээр зүйлсийг өвлөх бөгөөд Би түүний Бурхан болж, тэр Миний хүү болно.

-Илчлэлт 21:7

Та нар бол хөвгүүд нь мөн тул, Бурхан Өөрийн Хүүгийн Сүнсийг

бидний зүрхэнд илгээсэн байна. Тэр Сүнс Аав, Эцэг гэж дууддаг. Тиймээс чи цаашид боол биш, харин хүү нь мөн. Хэрэв хүү нь байх аваас Бурханаар дамжуулан өв залгамжлагч нь мөн байна.

-Галат 4:6,7

Хэрэв бид хүүхдүүд нь юм бол, өв залгамжлагчид нь бас мөн. Христгэй хамт алдаршуулагдахын тулд хэрэв бид үнэхээр Түүнтэй хамт зовдог юм бол, бид Бурханы өв залгамжлагчид бөгөөд Христийн хамтран залгамжлагчид юм.

-Ром 8:17

Хэрэв та нар Христийнх юм бол та нар Абрахамын үр бөгөөд амлалтын дагуу өв залгамжлагчид юм.

-Галат 3:29

БУРХАНЫ ШИЙДМЭГ ТӨС ТҮҮНИЙ ХҮҮГИЙН ТӨЛӨӨ

Бурханыг хайлрадаг, Түүний зорилгын дагуу дуудагдсан хүмүүст сайны төлөө Бурхан бүх юмыг хамтдаа амилуулдаг гэдгийг бид мэднэ. Тэр Өөрийнхөө Хүүг олон ах дүүсийн дунд ууган нь байлгахын тулд, урьдаас мэдсэн хүмүүсээ Тэр бас Түүний дүртэй адил болгохоор урьдаас тогтоосон юм.

-Ром 8:28-29

Тэгээд Бурхан Бид Өөрсдийнхөө дүр төрхийн дагуу Өөрсдтэйгөө адилхан хүнийг бүтээж, далайн загас, огторгуйн шувууд, мал адгуус, бүх газар дэлхий, газраар мөлхөгч бүгдийг тэдэнд захицуулья хэмээн айлдав.

-Эхлэл 1:26а

Христгэй адил үйлчлэл

Ширээнд тухлагч, үйлчлэгч хоёрын хэн нь агуу вэ? Ширээнд тухлагч нь биш гэж үү? Харин Би та нарын дунд үйлчлэгч мэт байдаг.

-Лук 22:27

Уучлагч байх

Тэгтэл Есүс түүнд: Үнэнээр би чамд хэлье. Онеөдөр чи надтай надтай хамт диваажинд байх болно гэлээ. -Лук 23:24

Номхон даруу ба дөлгөөн байх

Одоо Паул би өөрийн Христийн хүлцэл болон дөлгөөн байдлаар та нарыг ятгаж байна. Би та нартай нүүр учрахдаа хүлцэнгүй байгаад харин хол байхдаа зоригтой байдаг гэнэ.

-2Коринт 10:1

Христийн хайр дотор явах

Эцэг намайг яаж хайлласан шиг Би бас та нарыг хайлласан. Миний хайр дотор байгтун.

-Иохан 15:9

Даян дэлхийд сайн мэдээг дэлгэрүүл

Есүс дахин тэдэнд: Амар амгалан та нартай хамт байх болтугай. Эцэг намайг илгээсний адил Би та нарыг илгээнэ гэв.

-Иохан 20:21

БИДНИЙ АЛХАА БУРХАНЫ ХҮНДЭТГЭЛИЙГ ТАТАГЧ БАЙХ ёСТОЙ

29

Ингэснээр өөрсдийг чинь
Өөрийнхөө хаанчлалд болон алдарт
дууддаг Бурханд та нар зохистойгоор
явах юм.

-1Тесалоник 2:12

Хэтэрч, Христийн сургаал дотор
байдаггүй хэнд ч Бурхан байхгүй.
Сургаал дотор байгч нэгэнд Эцэг ч,
Хүү ч байна.

-2Иохан 9

Сорилтыг тэсвэрлэдэг хүн ерөөлтэй
еэ! Учир нь тэр соригдчихоод, Эзэний
өргөөг нь хайллагсдад амилсан амийн
титмийг хүлээн авна.

-Иаков 1:12

Над уруу ирж, үгийг минь сонсоод
түүнийхээ дагуу үйлдэгч аливаа хүн
хэнтэй адил болохыг та нарт Би
харуулья. Тийм хүн нь барьж буй

байшигийнхаа суурийг газраа гүн
ухаад хадан суурилсан нэгэнтэй адил
юм. Үер бууж гол халин байшинг
нүдсэн боловч хөдөлгөж чадсангүй.
Юу гэвэл байшин бат бөх баригдсан
ажээ.

-Лук 6:47,48

Ингэхдээ бид өөрсдийн агуу Бурхан
ба Аврагч болох Есүс Христийн цог
жавхлант илэрхийлэл хийгээд ерөөлт
найдварыг хүлээдэг.

-Тит 2:13

ТҮҮНИЙ УРАН ХИЙЦ

Учир нь нигүүлслээр та нар итгэлээр аврагдсан юм. Энэ нь та нараас биш харин Бурханы бэлэг бөгөөд үйлсээр биш аж. Тиймээс хэн ч өөрөөрөө сайрхахгүй болно. Учир нь бид сайн үйлсийн төлөө Христ Есүс дотор бүтээгдсэн Түүний бүтээл мөн. Бурхан биднийг тэдгээрийн дотор яваасай гэж урьдаас бэлтгэсэн билээ.

-Эфэс 2:8

Эдүүгээ бидний дотор ажилдаг хүчний дагуу гүйж, бодох бүхнээс минь илүү хэмжээлшгүй бялхалаар үйлдэх чадвартай Түүнд алдар нь чуулган дотор, Христ Есүс дотор бүх үеийнхэнд үеийн үед байх болтугай. Амен.

-Эфэс 3:20-21

Та нарын итгэл хүмүүсийн мэргэн ухаан дотор бус харин Бурханы хүч

дотор байхын тулд юм.

-1 Коринт 2:5

**Түүн дотор сэвгүй ба дүүрэн бүтээл
байх болно**

Учир нь Христ болгогдогсдыг ганц тахилаар үүрд төгс болгожээ.

-Еврей 10:14

Бид бүгд итгэл хийгээд Бурханы Хүүг мэдэх мэдлэгийн нэгдэл хүртэл, төлөвшсөн хүн болтол, Христийн дүүрэн байдлын чанарын хэмжээнд хүртэл ингэх ажээ.

-Эфэс 4:13

Учир нь бүх Бурханлаг бүрэн дүүрэн нь Түүний дотор биет хэлбэрээр оршидог юм. Түүний дотор та нар төгс болгогдсон. Тэр бол бүх удирдлага ба эрх мэдлийн тэргүүн мөн.

-Колоссай 2:9-10

Тэр анх төрсөн Түүнийг дахин дэлхийд авчрах үедээ Бурханы бүх тэнгэр элч нар Түүнд мөргөгтүн гэж айлдажээ.

-Еврей 1:6

Түүний газар болох дэлхийд баярлан, хүмүүсийн хөвгүүдээр баходан байв.

-Сургаалт үгс 8:31

Тийм учраас ах дүү нар минь, та нар Христийн биеэр дамжуулан хуульд үхсэн. Ингэснээр Бурханы төлөө бил Үр жимс гаргахын тулд үхэгсдээс амилуулсан өөр Нэгэнтэй та нар холбогдох юм.

-Ром 7:4

Нэг биед олон эрхтэн байдгийн адил, мөн бүх эрхтэнд ижил үйл ажиллагаа байдаггүйн адил, бид олуулаа Христ дотор нэгэн бие болой.

Харин хүн нэг бүр нэг нэгэндээ эрхтэн юм.

-Ром 12:4-5

Түүнээс амьдрал авсан сүйт бүсгүй
Хүүтэй хүнд амь бий. Бурханы Хүү байхгүй хүнд амь байхгүй.

-Иохан 5:12

Сүйт бүсгүйн төлөөх бүх хайр

Тэр Өөрийн Хүүгээ үл өршөөж, харин Түүнийг бид бүхний төлөө тушаасан юм. Тэгвэл Тэр яаж бүх юмыг Түүний хамт билэнд сул өгөхгүй байх билээ.

-Ром 8:32

ХААН СУУДЛЫН ХУВЬ! ХЭН, НАДАД?

**Хаан суудлаа Өөрийн сүйт
бүгүйтэйгээ хуваалщана**

Би ялж, Эцэгийнхээ хамт Түүний сэнтийнд заларсны адил надтай хамт Миний сэнтийнд залрахыг ялагчид соёрхоно.

-Илчлэлт 3:21

Хааны хот ба сүйт бүсгүй

Харин тэд үлэмж дээр нутгийг хүсэж байв. Тэр бол тэнгэрлэг орон мөн. Тиймээс Бурхан нь тэдний Бурхан гэж нэрлэгдэхдээ тэднээс ичээгүй юм. Учир нь Тэр тэдний төлөө хотыг бэлджээ.

-Еврей 11:16

Би ялагчийг Өөрийн Бурханы сүм дэх багана болгоно. Тэр цаашид тэндээс гарахгүй. Би түүн дээр Өөрийн Бурханы нэр, тэнгэрээс Миний Бурханаас буун ирэх шинэ Иерусалим

буюу Өөрийн Бурханы хотын нэр, Өөрийн шинэ нэрээр бичнэ.

-Илчлэл 3:12

Ариун хот, шинэ Иерусалим нь нөхөртөө очихоор гоёсон сүйт бүсгүй мэт бэлтгэгдэн Бурханаас гарч, тэнгэрээс буун ирэхийг би харлаа.

-Илчлэлт 21:2

Амийн мод уруу очих эрхтэй болохын тулд болон хаалгаар хот уруу орохын тулд дээлээ угаагчид нь өрөөлтэй еэ.

-Илчлэлт 22:14

Иймээс хэрэв та нар шударга бус эд баялагт итгэмжтэй байгаагүй бол, хэн та нарт жинхэнэ баялгийг даатгах билээ.

-Лук 16:11

Учир нь та нар бидний Эзэн Есүс Христийн нигүүлслийг мэднэ. Хэдийгээр Тэр баян боловч Оөрийнхөө ядуурлаар та нарыг баян болгохын тулд Тэр ядуу болжээ.

-2Коринт 8:9

Миний хайрт ах дүү нараа сонсогтун. Бурхан энэ ертөнцийн ядуусыг Өөрийг нь хайлрагсдад амласан хаанчлалын өвлөгчид болгож, тэднийг итгэл дотор баян байлгахын тулд сонгоогүй гэж үү.

-Иаков 2:5

Би чиний зовлон шаналал, ядуу байдлыг болон өөрсдийгүй иудейчүүд хэмээгчдээр доромжлогддогийг чинь Би мэднэ. Харин тэд иудейчүүд биш бөгөөд Сатаны синагог юм.

-Илчлэлт 2:9

Газрын баялагууд аюултай

Чи энэ үеийн ертөнцийн баячуудад хандан биеэ бүү тоо, эд хөрөнгөний тодорхойгүй байдалц найдвар бүү тавь, харин биднийг баясаж цэнгэх бүх зүйлсээр элбэг хангадаг Бурханд найд хэмээн тушаа. Сайныг үйлдэж, сайн үйлсээрээ баян болж, өглөгч бөгөөд хуваалцахад бэлэн бай хэмээн тэдэнд тушаа. Ингэхдээ тэд ирээдүйн төлөө өөрсөддөө сайн үндэс суурийн эрдэнэсийг хурааснаараа жинхэнэ аминд хүрэх юм. -1Тимот 6:17-19

ЯМАР ҮНЭН БАЯЛАГУУДЫГ НАДААС ХҮСЭХ БАЙНА ВЭ?

Тэр бүх юмсыг Өөртөө захицуулж чадах хүчээрээ бидний дорд биеийг Өөрийнхөө цог жавхлант бистэй адил болгон өөрчилнө.

-Филиппой 3:21

Эцэгт талархал өргөгтүн. Гэрэл дотор ариун хүмүүсийн өвийг хуваалцахад Тэр биднийг зохистой болгосон. Учир нь Тэр биднийг харанхуйн эрх мэдлээс авраад, Өөрийн хайрт Хүүгийнхээ хаанчлалд шилжүүлсэн юм.

-Колоссай 1:12-13

Эдүгээ та нарыг босгон, ариусгагдсан бүхний хамт өв залгамжлалыг өгөх чадалтай Бурханд ба Түүний нигүүлслийн үгэнд би та

нарыг даатгаж байна.

-Үйлс 20:32

Бидний амь болох Христ илчлэгдэх үед та нар ч бас яруу алдар дотор Түүний хамт илчлэгдэх болно.

-Колоссай 3:4

Харь үндэстнүүд энэхүү биеийн хамтран өв залгамжлагчид ба эрхтнүүд болох бөгөөд сайн мэдээгээр дамжуулан Христ Есүс дотор амлалтыг хамтран хуваалцагчид болжээ. Бүх ариун хүмүүсээс хамгийн өчүүхэн нь болох надад энэхүү нигүүлсэл өгөгдсөний учир нь Христийн нэвтэршгүй баялгийг харь үндэстэнд тунхаглахын тулд байлаа.

-Эфэс 3:6,8

БИ БАЯСАНА БИ БОЛ ТАНЫХ, ЭЗЭН!

35

Таныг эрэн хайгч бүхнийг
Өөрийнхөө дотор баярлуулаач. Таны
авралыг хайллагсдаар “ЭЗЭН
дээдлэгдэх болтугай” гэж үргэлж
хэлүүлээч.
-Дуулал 40:16

Зөв шударга хүмүүс ээ, та нар ЭЗЭН
дотор баярлаж, баясгатун. Зүрхээрээ
шuluун шударга бүгд ээ, та нар
баярлаж хашгирагтун!

-Дуулал 32:11

Эзэний дотор үргэлж баярла. Би
дахин хэлнэ. Баярлагтун!

-Филиппой 4:4

Учир нь цаг зуурын ялихгүй зовлон
нь бидэнд мөнх алдрыг үлэмж
арвинаар бий болгож байна.

-2Коринт 4:17

Сионы охин оо, үлэмж ихээр
баярлагтун! Иерусалимын охин оо!
Ялалтын уухай хадаагтун! Үзэгтүн,
хаан чинь чам уруу очиж байна. Тэр
бол зөв шударга, ялагдашгүй.

-Зехария 9:9a

Гэсэн хэдий ч сүнснүүд эрхшээлд
чинь орсон гэдэгт та нар бүү баярла,
харин нэрс тань тэнгэрт бичигдсэн
гэдэгт баярлагтун гэв.

-Лук 10:20

Харин Танд хоргодогч бүгд баяр
хөөртэй байж, мөнхөд баярлан дуулах
болно. Таны нэрийг хайллагчид Танд
баярлахын тулд тэднийг Та хамгаалаач.

-Дуулал 5:11

ТА УҮРДИЙН НИГҮҮЛСЛИЙГ ҮЛ ХҮЛЭЭН АВАХ УУ?

Харин миний эсрэг нүгэл үйлддэг хүн өөрийгөө гэмтээдэг. Намайг үзэн ядагч бүхэн нь үхлийг хайлрагч болой.

-Сургаалт үтс 8:36

Айлдагчийг хэрэгсэхгүй байхаас та нар сэрэмжил. Учир хэрэв газар дээр тэдэнд сануулсан түүнийг тэд үл хэрэгсээд зугтчихааргүй бол тэгэх тусмаа тэнгэрээс сануулагч Түүнээс бид нүүр буруулан зугтаж чадна гэж үү?

-Еврей 12:25

Тэр тэдэнд: Нарийн хаалгаар орохыг хичээ. Би та нарт хэлье. Олон хүмүүс орохыг эрэлхийлэвч чадахгүй. Нэгэнтэй өрхийн тэргүүлэгч босож хаалгаа түгжвэл, та нар гадна нь

зогсоод, хаалгыг тогшин “Эзэн, бидэнд онгойлгооч” гэхэд чинь Тэр та нарт хариуд нь “Та нар хаанаас ирснийг Би мэдэхгүй” гэнэ.

-Лук 13:24,25

-Нигүүлсэл нь уур хилэн болж хувирч чадна

Бузар муугийн зүсэн бүрийн заль мэхтэйгээр мөхөгсдийн төлөө ирнэ. Яагаад гэвэл тэд аврагдахын тулд үнэний хайрыг хүлээн аваагүй. Тиймээс Бурхан тэдний дээр төөрөгдлийн ажиллагааг илгээдэг. Тэгээд тэд худал хуурмагт итгэх болно. Ингэснээр үнэнд итгээгүй, харин бузар мууг таалсан бүх хүн яллагдах болно.

-2Тесалоник 2:10-12

Гэмийн дуургэлт, шийтгэгдсэн

Түүнд итгэдэг хүн яллагдахгүй.
Харин үл итгэдэг хүн аль хэдий
яллагдсан. Учир нь тэр хүн Бурханы
цорын ганц Хүүгийн нэрд итгээгүй
юм.

-Иохан 3:18

Хэрэв бид үнэний мэдлэгийг хүлээн
авсаны дараа санаатайгаар нүгэл
үйлдвэл нүглийн төлөөх тахил цаашид
үлдэхгүй. Харин шүүлт хийгээд
эсэргүүцэгчдийг шатаах галын хилэнг
айн чичирч хүлээх нь үлдэнэ.

-Еврей 10:26,27

Үгээр шүүх болно

Намайг голж, Миний үгийг хүлээж
авдаггүй хүнийг шүүх шүүгч бий.
Миний хэлсэн үг эцсийн өдөрт
түүнийг шүүнэ.

-Иохан 12:48

Өөрийн хайрыг илэрхийлсэн

Бурхан Өөрийнхөө цорын ганц Хүүг
ертөнцөд илгээсэн нь Түүгээр
дамжуулан биднийг амьд байлгахын
тулд юм. Үүгээр Бурханы хайр бидэнд
илэрхийлэгдсэн юм.

-Иохан 4:9

Сүns болон сүйт бүсгүй: Ирээрэй
гэнэ. Сонсогч нь: Ирээрэй гэж хэлэг.
Цангасан нэгэн нь ирэг. Хүссэн нэгэн
нь амиийн усыг үнэгүй аваг.

-Илчлэлт 22:17

Мунхаг нэг нь л тамд сатантай хамт мөнхөд зовлон эдлэн амьдрах бөгөөд харин та Христ дотор л байвал бүх өтрөнцийн хаан ширээ болон үгээр илэрхийлшгүй үүрдийн баяр баясгаланг хүртэх болно!

Мунхаг хүн зүрхэндээ “Бурхан байхгүй” гэв.

-Дуулал 53:1a

Харин Эээн түүнд: Фарисайчууд та нар аяга, тавагныхаа гаднахыг цэвэрлэдэг ч, харин та нар дотроо хулгай дээрэм, хар санаагаар дүүрэн байдаг. Мунхгуудаа, гаднахыг хийсэн Тэр доторхыг мөн хийгээгүй гэж үү?
-Лук 11:39,40

Эдгээр үгсийг минь сонсоод, үүний

дагуу үл үйлддэг аливаа хүн элсэн дээр байшингаа барьсан мунхаг хүнтэй зүйрлэгдэнэ. Бороо орж, үер буун, салхи салхилж, байшиг нүдсэнд байшин нурав. Эвдрэл нь асар их байлаа.

-Матай 7:26,27

Тиймээс Үхэгсдийн орон хоолойгоо өргөсгөн, амаа хязгааргүй ангайлгав. Иерусалимын сүр жавхлан, олон түмэн, түүний дуу чимээ, хөгжил, баясал тийшээ бууна.

-Исаиа 5:14

Шударга бусаар эд хөрөнгөтэй бологч нь гаргаагүй байж өндөг дарагч ятуутай адил юм.

-Иеремиа 17:11

**Хаадын Хаадыг хүлээн аваагүй
бүхэн хаашаа явах вэ?**

Харин хэрвээ тэр нь хогийн ургамлууд болон халгайнуудыг ургуулбал хэрэггүй болж, хараалд ойртон, шатаагдаж төгсдөг.

-Еврей 6:8

Хүний Хүү тэнгэр элч нараа илгээхэд тэд хамаг бүдрүүлэх саад болоод ёс бусыг үйлдэгч хүмүүсийг Түүний хаанчлалаас гаргаж бөөгнүүлээд галтай зууханд хаяна. Тэнд тэд уйлна, шүдээ хавирна.

-Матай 13:41-42

Тэдний зовлон тарчлалын утаа үеийн үед суунаглана. Араатан ба түүний хөрөт мөргөгсөд, Түүний

нэрийн тэмдгийг хүлээн авагч аливаа хүн өдөр ч, шөнө ч амрахгүй.

-Илчлэлт 14:11

...Олон хүмүүс Христийн загалмайн дайснууд мэт явдаг гэж би одоо уйлан байж хэлж байна. Тэдний төгсгөл бол сүйрэл.

-Филиппой 3:18б,19а

Гэвч Бурхан нэгэн гайхамшиг бүтээсэн юм. Тэрээр биднийг там уруу явуулахыг хүсээгүйгээр барахгүй бидний төлөө тамын мөнхийн үхлийг устгасан бөгөөд сэргэн мандах яалтын хүчүүг бидэнд олгосон билээ. Өөр гайхамшигууд гэвэл Түүнд дуулгаваргүй байсан нүгэлт хүмүүс, Христ дотор хайрын шинэ зүрх сэтгэлээр өөрчлөгднө.

ХААДЫН ХААН НЬ САТАНЫГ ШОРОНД ХИЙХ БОЛНО

Гартаа ёроолгүй гүнийн түлхүүр, асар том гинжтэй тэнгэр элч тэнгэрээс бууж ирэхийг би харав. Тэрээр диавол ба Сатан болох эртний мөгой буюу лууг бариад, түүнийг хүлж, мянган жилийн турш ёроолгүй гүнд хаяжээ. Тэгээд мянган жилийг нь дуусталүндэстнүүдийг цаашид мэхлүүлэхгүйн тулд түүнийг түгжээд лацдав. Үүний дараа тэр ахархан хугацаанд суллагдах ёстой аж.

-Илчлэлт 20:1-3

Мянган жил төгсөх үед Сатан шоронгоосоо суллагдан, тэднийг мэхэлсэн диавол хүхэр бүхий галт нуурт хаягдлаа. Тэнд ч мөн араатан болоод хуурамч эш үзүүлэгч байгаа аж.

Тэд өдөр шөногүй үеийн үед тарчилна.
-Илчлэлт 20:7,10

Сатанаас дээгүүрх мөнхийн ялалт

Түүнхүү хүүхдүүд нь цус ба махран биеийн тасархай болов. Түүнчлэн Тэр өөрөө бас тасархай болсон. Ингэснээр Тэр үхлийн хүч буюу диаволыг үхлээрээ устгасан.

-Еврей 2:14

ХОЖИМ ХЭНД ҮЙЛЧЛЭХ ТАЛААР ТА ОДОО ШИЙД

41

Хэн ч хоёр эээнд үйлчилж чадахгүй.
Тэр нэгийг нь үзэн ядаж, нөгөөг нь
хайрлах болно. Эсвэл нэгээс нь зуурч,
нөгөөг нь зэвүүцнэ. Та нар Бурхан
боловод эд баялагт хоёуланд нь зэрэг
үйлчилж чадахгүй.

-Матай 6:24

**Та Сатаны шорныг уу, эсвэл хаадын
Хaanы мөнхийн сүр жавхлангийн
хаан ширээг дагах уу?**

Тэдний нүдийг нээлгэж, тэднийг
харанхуйгаас гэрэл уруу, сатаны
эрхшээлээс Бурхан уруу эргүүлэхийн
тулд юм. Тэгснээрээ тэд Надад итгэх
итгэлээр ариусгагдсан хүмүүсийн дунд
нүглийн учал ба өвийг хүртэх болно
гэсэн.

-Үйлс 26:18

Хэрэв Надад үйлчлэх хүн байвал,

Намайг дага. Хаана Би байна, тэнд бас
Миний зарч байх болно. Хэрэв хүн
Надад үйлчилбэл, тэр хүнийг Эцэг
минь хүндэлнэ.

-Иохан 12:26

Харин хулчгар, итгэлгүй, жигшүүрт,
алуурчид, завхай хүмүүс, мэрэг
төлөгчид, шүтээнд мөргөгчид болон
бүх худалч хүмүүсийн хувьд, тэдэнд
оногдох хувь нь хоёр дахь үхэл буюу
хүхэр, галаар шатаж буй нуурт байна
гэв.

-Илчлэлт 21:8

Есүс тэдэнд: Үнэнээр, үнэнээр Би
та нарт хэлье. Нүгэл үйлдэгч бүр
нүглийн боол мөн. Боол гэрт мөнхөд
байдаггүй, харин Хүү л мөнхөд байдаг.
Иймээс хэрэв Хүү та нарыг чөлөөлбөл
та нар үнэхээр эрх чөлөөтэй болно.

-Иохан 8:34-36

АМЬД УСНЫ УРСГАЛ МИНИЙ ХӨЛӨӨР УРСАНА

Есүс түүнд: Хэрэв чи Бурханы бэлгийг болон Надад уух юм өгөөч гэж байгаа хүн хэн болохыг мэдсэнсэн бол чи Түүнээс гүйхад Тэр чамд амийн усыг өгөх байсан.

-Иохан 4:10

Баярын их өдөр болох сүүлчийн өдөр Есүс зогсоод хаширан: Хэрэв цангасан хүн байвал, Над уруу ирж, уутгун.

-Иохан 7:37

Харин өөрт нь Миний өгөх уснаас уугч хэн ч хээзээ ч цангахгүй. Харин Миний өгөх ус тэр хүний дотор мөнх аминд хүртэл оргилох булаг болно.

-Иохан 4:14

Яагаад гэвэл сэнтийний голд байгаа

Хурга тэднийг хариулах амийн усны булгууд уруу хөтлөх болно. Бурхан тэдний нүднээс урсах нулимын бүрийг арчих болно гэлээ.

-Илчлэлт 7:17

Тэр надад Бурханы болон Хурганы сэнтийнээс гарах талст мэт гялалзсан амийн усны голыг үзүүлсэн нь гудамжных нь төвд байв. Голын хоёр талд арван хоёр төрлийн үр жимс ургуулан, сар бүр үр жимсээ боловсруулж буй амийн мод байлаа. Тэр модны навчис нь үндэстнүүдийг эдгээхийн тулд байв. Тэнд цаашид ямар ч хараал байхгүй байх болно. Мөн Бурхан ба Хурганы сэнтий түүний дотор байж, боолууд нь Түүнд үйлчилнэ.

-Илчлэлт 22:1-3

ЭЗЭНИЙГ ҮНЭН СЭТГЭЛЭЭР ХАЙХ

43

Харин эхлээд түүний хаанчлал болон Түүний зөвт байдлыг хайгтун. Тэгвэл энэ бүхний та нарт нэмж өгөх болно.

-Матай 6:33

Харин тэндээс чи өөрийн Бурхан ЭЗЭНийг эрэх болно. Хэрэв чи Түүнийг бүх зүрхээрээ, бүх сэтгэлээрээ эрвэл олно.

-Дэд хууль 4:29

Намайг хайллагсдыг Би хайлана. Намайг хичээнгүйлэн хайдаг нь Намайг олно.

-Сургаалт үгс 8:17

Би та нарт хэлье. Гуй, тэгвэл та нарт өгөгдөнө. Хай, тэгвэл та нарт олно. Тогш, тэгвэл та нарт нээгдэнэ.

-Лук 11:9

Зөв шударгыг тариалж, энэрэнгүй-гээр хурааж ав. Боловсруулаагүй газраа

хагал. Учир нь ЭЗЭН чиний дээр зөв шударгыг асгахаар ирэх хүртэл Түүнийг хайх цаг нь одоо билээ.

-Хосеа 10:12

Олдож болох үед нь ЭЗЭНийг хайгтун. Түүнийг ойр байгаа дээр нь дуудагтун.

-Исаиа 55:6

Миний нэрээр дуудагдсан Миний хүмүүс өөрсдийгөө даруу байлган, залбирч, Миний нүүрийг эрэлхийлж, бузар муу замуудаасаа эргэх аваас, Би тэнгэрээс сонсож, тэдний нүглийг учлан, тэдний газар нутгийг эдгээнэ.

-Шастирын дэд 7:14

Миний Бурхан ЭЗЭН, би бүх зүрхээрээ Танд талархаж, Таны нэрийг мөнхөд алдаршуулна.

-Дуулал 86:12

ГЭРЛЭГСДЫН ЗООГ - БУРХАН СҮЙТ БҮСГҮЙГЭЭ АВАХ БОЛНО

Нааш ир. Би чамд Хурганы эхнэр сүйт бүсгүйг үзүүлье гэв. Тэр намайг сүрлэг өндөр уулан дээр сүнс дотор аваачаад Бурханаас гарч, тэнгэрээс буун ирж буй ариун хот Иерусалимыг үзүүллээ. Түүнд Бурханы алдар нь байлаа. Би хотод ямар ч сүм харсангүй. Учир нь Төгс хүчтэй Эзэн Бурхан ба Хурга бол тэндхийн сүм юм. Хотод дээрээс нь гэрэлтүүлэх нар, сар хэрэггүй ажээ. Учир нь Бурханы цог жавхлан түүнийг гэрэлтүүлсэн бөгөөд дэнлүү нь Хурга байлаа. Үндэстнүүд тэр гэрлээр нь алхацгааж, газрын хаад тийшээ алдраа авчирна.

-Илчлэлт 21:9б-11а, 22-24а

Хурсан олон түмний дуу хоолой шиг, их усны шуугиан шиг, хүчтэй

аянгын нүргээ шиг дуу гаражыг би сонсов. Халлелу-яа! Төгч хүчтэй Эзэн бидний Бурхан хаанчилдаг. Баярлан хөөрч, баясан цэнгэж, Түүнд алдрыг өргөцгөө. Учир нь Хурганы хурим болж, Түүний сүйт бүсгүй өөрийгөө бэлдэв. Тэрээр гялалзсан, цэвэрхэн нарийн маалингаар хувцаслах болжээ. Учир нь тэрхүү нарийн маалинга бол ариун хүмүүсийн зөвт үйлс юм. Тэр надад “Хурганы хурмын зоогонд уригдагсад өрөөлтэй еэ!” гэж бичигтүн гээд эдгээр нь Бурханы үнэн үгс мөн гэлээ.

-Илчлэлт 19:6-9

БУРХАНД СҮЙТ БУСГҮЙ ЯМАР БАЙХ ЕСТОЙ ВЭ?

45

Түүнд номхон даруу

...Харин Бурханд өөрсдийгөө үхэгсдээс амьд болгогсод мэт, мөн биенийхээ эрхтнүүдийг зөвт байдлын зэвсэг болгон Бурханд өргө.

-Ром 6:13б

Болзоот залуугийн хайр

Бидний Эзэн Есүс Христийг ялзаршгүй хайраар хайллагч бүх хүмүүст нигүүлсэл байх болтугай.

-Ефэс 6:24

Түүнтэй хамт нэг

Яагаад гэвэл бид Түүний биеийн эрхтнүүд юм. -Ефэс 5:30
ингэснээр та нар энэ дэлхийн тачаалаар байх ялзралаас ангижирснаар бурханлаг мөн чанарын хуваалцагч болох юм. 2Петр 1:4б

Ямарч өө сэвгүй

Тиймээс хайртууд минь, та нар

эдгээрийг хүлээж буй учраас амар амгалан дотор болон толбогүй бөгөөд гэм зэмгүйгээр Түүнд олдохыг хичээгтүн.

-2Петр 3:14

Хонгор минь, чи бүхэлдээн үзэсгэлэнтэй бөгөөд чамд ямар ч өө сэв алга.

-Соломоны дуун 4:7

Тэнгэрлэг хүчээр дүүрэн

Тэрээр махан биед хамаатай тушаалын хуулийн үндсэн дээр бус, харин мөхөшгүй амиин хүчээр гарч ирсэн юм.

-Еврей 7:16

Тэнгэрлэг хайраар дүүрэн

Харин Түүний үгийг сахьдаг хэний ч дотор Бурханы хайр үнэхээр төгс болгогджээ.

-1Иохан 2:5а

Туйлын их нигүүлсэлтэй байх болно

Есүс Христийн илчлэлт дээр та нарт өгөгдхөн нигүүлсэлд найдвараа бүрэн тавь.

-1Петр 1:13б

ХААН ДЭЛХИЙН ЭСЭРГҮҮЦЭГЧ НАРЫГ УСТГАХ БОЛНО

Тэд Хурганы эсрэг дайн хийх бөгөөд Хурга тэднийг ялах болно. Учир нь Тэр эздийн Эзэн, хаадын Хаан билээ. Түүнтэй хамт байгчид нь дуудагдсан, сонгогдсон, итгэмжит хүмүүс юм гэв.

-Илчлэлт 17:14

Хүчит нэгэн тэнгэр элч тээрмийн асар том чулуу шиг чулууг авч тэнгис үруу чулуудангaa: Агуу хот Вавилон ийнхүү хүчээр доош хаягдана. Тэгээд хойшид олдохгүй.

-Илчлэлт 18:21

Дараа нь ёс бус нэгэн нь илчлэгдэх бөгөөд Эзэн Есүс амныхаа амьсгалаар түүнийг алж, Оөрөө ирж үзэгдсэнээрээ төгсгөлийг нь авчирна.

-2Тесалоник 2:8

Иерусалимын эсрэг дайнд мордох

бүх ард түмнүүдийг ЭЗЭНий цохих гай гамшиг нь энэ байх болно. Тэд хол дээрээ зогсож байхад нь махан бие нь ялзарч, ухархайдаа нүднүүд нь байж амандаа хэл нь өмнийрнө.

-Зехария 14:12

Тэр бүх удирдлага, эрх мэдэл, хүчийг хүчингүй болгон, Бурхан ба Эцэгт хаанчлалыг тушаах үед төгсгөл ирнэ.

-1Коринт 15:24

1000-ЖИЛ ТҮҮНТЭЙ ХАМТ ГАЗАР ДЭЭР ХААНЧЛАХ БОЛНО

47

Таны хаанчлал ирэх болтугай. Хүсэл тань тэнгэр шигээ газар дээр биелэгдэх болтугай.

-Матай 6:10

Дөлгөөн хүмүүс ерөөлтэй еэ! Учир нь тэд дэлхийг өвлөн авах болно.

-Матай 5:5

Ертөнцийн хаанчлал нь бидний Эзэний болон Түүний Христийн хаанчлал болсон. Тэр үеийн үед хаанчилна гэх чанга дуу гарлаа.

-Илчлэлт 11:15б

...Учир нь Та нядлуулсан бөгөөд бүх овог хэл ,ард түмэн болон үндэстнүүдээс хүмүүсийг Бурханд Оөрийнхөө цусаар худалдан авч өгсөн билээ. Та тэднийг бидний Бурханы төлөөх хаанчлал ба тахилч нар болгосон. Тэд дэлхий дээр хаанчлах болно гэцгээж байлаа.

-Илчлэлт 5:9б,10

Би сэнтийнүүдийг харав. Тэд дээр нь заларчээ. Тэдэнд шүүх эрх өгөгдсөн байлаа. Мөн Есүсийн гэрчлэл болон Бурханы үгээс болж цаазлуулсан хүмүүсийн болон араатанд ба Түүний хөрөгт мөргөөгүй, дүх хийгээд гар дээрээ араатны тэмдгийг хүлээн аваагүй хүмүүсийн сэтгэлүүдийг би харав. Тэд амилаад Христтэй хамт мянган жилийн турш хаанчилжээ.

-Илчлэлт 20:4

Анхны амилалтанд багтсан хүн ерөөлтэй бөгөөд ариун юм. Хоёр дох үхэл тэднийг захираг ямар ч хүчгүй ажээ. Харин тэд Бурханы ба Христийн тахилч нар болцгоож, Түүнтэй хамт мянган жилийн турш хаанчлах болно.

-Илчлэлт 20:6

ШИНЭ ХҮРГЭНТЭЙ ҮҮРД МӨНХ АМЬДАРНА

**Бурхан ба би дуусашгүй баяр
баясгаланд хүрэх болно**
Оө, Хаан болох Бурхан минь, би
Таныг өргөмжилж, Таны нэрийг үүрд
мөнхөд магтана.

-Дуулал 145:1

**Аав аа, Таны Надад өгсөн хүмүүс бас
Миний байх газарт Надтай хамт байж,**
Миний сүр жавхланг үзээсэй гэж Би
хүсэж байна. Тэгээд тэр сүр жавхланг
Та Надад өгсөн билээ. Учир нь
ертөнцийн сууриас өмнө Та Намайг
хайлласан.

-Иохан 17:24

Тэгээд Христийн дотор үхэгсэд
эхлээд амилах болно. Дараа нь амьд
хийгээд үлдсэн бид тэдэнтэй хамт

агаар мандалд Эзэнтэй уулзахаар үүлэн
дотор өргөгдөж, тийнхүү Эзэнтэй
үргэлж хамт байх болно.

-1 Тесалоник 4:166-17

Харагтуун, Бурханы асар хүмүүсийн
дунд байна. Тэр Тэдний дунд нутаглах
болно. Тэд Түүний ард түмэн болж,
Бурхан Оөрөө тэдний дунд байж
тэдний Бурхан нь болно.

-Илчлэлт 21:36,4

Тэнд цаашид шөнө болохгүй. Эзэн
Бурхан тэднийг гийгүүлэх учраас
тэдэнд дэнлүүний гэрэл ч, нарны гэрэл
ч хэрэггүй болно. Учир нь Бурхан
тэднийг гийгүүлнэ. Тэгээд тэд үеийн
үед хаанчлах болно.

-Илчлэлт 22:5

ЕСҮС ХРИСТ ХЭЛЭХДЭЭ:

Би ялж, Эцэгийнхээ хамт Түүний сэнтийнд заларсны адил Надтай хамт
Миний сэнтийнд залрахыг ялагчид соёрхоно.

-Илчлэлт 3:21

Өө, агуу их хайрыг Аврагч маань харуулахдаа
Огөр модон дээр ичгүүрт үхлээр үхсэн юм,
Оөрийн сүр жавхлант сэнтийгээ орхио
Оөдгүй нүгэлт намайг аврахаар ирсэн юм.

- И.Н. МкХосе

Эзэн алдаршиг, Тэрээр ариун бөгөөд шударга;
Эзэн алдаршиг, Тэр хумхийн тоос болон намайг хайлрадаг юм.
Эзэн алдаршиг, Түүнд би үйлчлэх учиртай!
ЭЗЭН АЛДАРШИГ! ЭЗЭН АЛДАРШИГ! ЭЗЭН АЛДАРШИГ!

-Ватсон Гуудман

05/02

40M